



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/152

Чингис хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар болон Нэгдсэн Үндэстний байгууллагын хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн хооронд байгуулсан "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" нэмэлт санхүүжилт төслийн санхүүжилтээр 2020 онд Хэнтий аймагт хийгдэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны

дарга:

Ц.Чогсомжав

Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн

дарга:

Ч.Мөнх-Эрдэнэ

Аймаг хариуцсан төслийн  
ажилтан

Гишүүд:

Ц.Бат-Эрдэнэ

Аймгийн Засаг даргын Тамгын  
Газрын Хөрөнгө оруулалт,  
хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн  
мэргэжилтэн

Ц.Мөнхтулга

Мал эмнэлгийн газрын  
Захиргаа, санхүүгийн албаны  
дарга

Ц.Одгэрэл

Өмнөдэлгэр сумын төслийн  
ажилтан

Ж.Ганбат

"Хэнтий-Ус" ХХК-ийн Дотоод  
хяналт


Д.Оюун

Төрийн бус байгууллагын  
төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Ц.Чогсомжав/-д үүрэг болгосугай.

3. Үнэлгээний хорооны зохион байгуулах төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА